



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 8 сарын 29 өдөр

Дугаар 340

Улаанбаатар хот

“Монголросцветмет” төрийн өмчит
үйлдвэрийн газрын 2019 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөнд тодотгол хийх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 6 дахь хэсэг, “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 5.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотголыг хавсралтаар баталсугай.

2. Үйлдвэрийн газрын 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний тодотголд үндэслэн худалдан авалтын төлөвлөгөөний тодотголыг баталж, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг захирал /Б.Мөнхбат/-д үүрэг болгосугай.

3. Нийгмийн хариуцлагын хүрээнд Бэрх хотын ирээдүйн хөгжил цэцэглэлт, тохижилт үйлчилгээ болон үндэсний их өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлахад зориулан нийт 100.0 сая төгрөгийн зардлыг “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын нийгэм соёлыг хөгжүүлэх сангаас санхүүжүүлэхийг захирал /Б.Мөнхбат/-д зөвшөөрсүгэй.

4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

Б.ЭРДЭНЭБАЯР

0000673

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 8 дугаар сарын 29-ны өдрийн
340 дугаар тогтоолын хавсралт

**"МОНГОЛПРОСЦВЕТМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛ**

№	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛУУД	Хэмжих нэгж	2019 төлөвлөгөө	2019 тодотгол	Нийт
1	Техник төхөөрөмжийн худалдан авалт	мян.төг	5,615,902.0	286,487.0	5,902,389.0
2	Техник, тоног төхөөрөмжийн их засварын ажил	мян.төг	3,546,777	-184,156.0	3,362,621.0
3	Шинээр худалдан авах үндсэн хөрөнгийн төсөв	мян.төг	5,912,178	471,670.0	6,398,848.0
4	Барилга байгууламж, бүтээн байгуулалтын ажил	мян.төг	48,800.0	0	48,800.0
5	Зураг төсөл, судалгаа шинжилгээний ажил	мян.төг	1,346,753.0	135,000.0	1,481,753.0
6	Геологи хайгуулын ажил	мян.төг	1,004,422.0	-135,000.0	869,422.0
7	"Монголын далд уурхайн сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв" байгуулах төсөв	мян.төг	1,327,517.0	-574,000.0	753,517.0
	НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		18,802,348 (арван найман тэрбум, найман зуун хоёр сая гурван зуун дөчин найман мянган төгрөг)	0	18,802,348 (арван найман тэрбум, найман зуун хоёр сая гурван зуун дөчин найман мянган төгрөг)